

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журам, зааварт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/246 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам”-ын “Өндөр насны тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн үндэслэл болон бүрдлийг хянах” гэсэн 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтын “Санамж⁴”, “Санамж¹³”-ийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“Санамж⁴”.Даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтэр дэх 1995-2006 оны шимтгэл төлөлтийг ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан (НД-7, НД-8)-тай тулган хянана. Хэрэв даатгуулагчийн энэ хугацааны шимтгэл төлөлт нь ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (НД-7, НД-8)-гаар нотлогдохгүй эсхүл дэвтэр нь үрэгдсэн бол холбогдох нийгмийн даатгалын газрын архивын лавлагаа, QR код бүхий шимтгэл төлөлтийн лавлагааг үндэслэнэ;

Санамж¹³.Хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагчаас энэ журмын 1.2-т заасан ажлаас чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийг авна.

Хоёр.Мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Тэтгэвэр бодох заавар”-ын “Тэтгэврийг өөрчлөн тогтоох” гэсэн 6 дахь хэсгийн 6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

6.1.Энэ зааврын 2.1-д заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчаас бусад тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж албан журмаар даатгуулж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэврийн хэмжээг анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлснөөс тооцон шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар тооцон нэмэгдүүлнэ.

Энэ тохиолдолд Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 450 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 6 сар ба түүнээс дээш хугацаанд шимтгэл төлсөн бол тэтгэврийг өөрчлөн тогтоох бөгөөд тэтгэвэр авагч хүсэлт гаргаагүй тохиолдолд нэмэгдлийг хийхгүй. Харин тухайн тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд 6 сараас доош хугацаанд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сараар тооцон тэтгэврийг нь нэмэгдүүлж болно.

Гурав.Журам, зааварт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар (Ц.Ганцэцэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын газар (С.Лхагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

ТӨСӨД